

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ГАЗАР, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН М.ГЭРЭЛТУЯАГИЙН 2025 ОНЫ II УЛИРАЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээий биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
Зорилт 1. Улсын төсөв, гадаадын зээл тусламжаар хэрэгжих хөрөнгө оруулалтын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөх үйл ажиллагаа							
1.	Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна.	Зураг төслийн гүйцэтгэлийн хувь	5%	30%	Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад 2024 онд зураг, төсөв боловсруулах нэмэлт хөрөнгө батлагдаж, Төрийн худалдан авах ажиллагааны газарт худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж, гүйцэтгэгчээр “Бодь пропертийз” ХХК болон “Төгс гранд констракшн” ХХК-ийн түншлэл 2,400.0 сая төгрөгөөр шалгарч гэрээ байгуулж зураг төсөв боловсруулагдаж байна. Хавдар судлалын үндэсний төв-2 цогцолбор байгуулах зориулалтаар Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр	2025-01-01 2025-12-31	100%

					хорооны Баянголын аманд 12 га газар эзэмших гэрчилгээ нь олгогдсон. Мөн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн XVIII.1.54. Хавдар судлалын үндэсний төв-2 төсөл арга хэмжээнд 10,000.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5,000.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, 7.0 тэрбум төгрөгийн гадна инженерийн шугам сүлжээний ажил, 3.0 тэрбум төгрөгийн цогцолборын хашаа барих санхүүжилтийн эрхийг НЗДаргад шилжүүлсэн боловч		
2.	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна.	Гадна инженерийн шугам, сүлжээний ажлын гүйцэтгэлийн хувь	26%	40%	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд "Халдварт өвчин судлалын үндэсний төв-2"-ийн гадна инженерийн шугам, сүлжээ /Төв, Сэргэлэн сум/ -ний ажил батлагдаж "Эм Си Эс Си" ХХК болон "Солармед Монгол" ХХК-ийн түншлэлтэй 18.7 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Гадна инженерийн шугам, сүлжээний газар, шорооны ажил, барилга байгууламжийн каркас угсралтын ажил хийгдэж дууссан, ажлын гүйцэтгэл 40%-тай байна.	2025-01-01 2025-12-31	100%
3	Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	5%	10%	Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн XVIII.1.45. Эс, эд, эрхтэн шилжүүлэн суулгах төв /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/ төсөл арга хэмжээ батлагдаж, "Магнуссентурион Констракшн" ХХК болон "Сетунари" ХХК-ийн түншлэлтэй 2024 онд 139,9 тэрбум төгрөгийн гэрээг байгуулсан. 2025	2025-01-01 2025-12-31	100%

					оны төсвийн тухай хуулиар 32.0 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд эхний хагас жилийн байдлаар барилгын ажлын гүйцэтгэл 15 хувьтай, 5,253.2 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.		
	Арга хэмжээ 1.5. Зүрх судасны төв байгуулна.	Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэсэн байна	Санхүүжилтийн өмнөх хэлэлцэ эр байгуул агдсан	-	“Зүрх Судасны Үндэсний Төв”(ЗСҮТ) байгуулах төслийг Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр ТЭЗҮ, зураг төслийг боловсруулсан. Тус эмнэлгийн барилга нь Улаанбаатар хот, УГТЭ-ийн хашаанд төлөвлөгдсөн ба зураг төсөл, ТЭЗҮ -г Испани Улсын “Идом” ХХК 1,5 сая еврогоор гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар 2022 онд баталгаажсан. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх хүсэлтийг ЭЗХЯ, СЯ-нд хүргүүлсний дагуу ЕСБХБанкны хөнгөлөлттэй зээлээр “Зүрх судасны үндэсний төв”-ийн барилгын төслийг санхүүжүүлэхээр 2024.09.30-ны өдөр МУ-ын ЭЗХЯам, СЯ, ЭМЯ болон ЕСБХБанк хамтарсан DTM55677 дугаартай “Санхүүжилтийн өмнөх гэрээ”-г байгуулсан. Уг гэрээний дагуу 120 ортой тусгай зориулалтын ЗСҮТөвийн барилга барьж ашиглалтад оруулах төслийн нийт өртөг 51,0 сая евро байх ба		

					ЕСБХБанк нь 30.0 сая евро хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлнэ. Тоног төхөөрөмжийн нийт өртөг 21.0 сая евро байх ба улсын төсөв болон Люксембургийн Их Гүнт улсын буцалтгүй тусламжаар санхүүжүүлэхээр тооцоолсон. Зээлийн хэлэлцээрийг 2025 оны 6 дугаар сард СЯ, ЭЗХЯ, ЭМЯ, ЕСБХБ, УГТЭ хамтран баталгаажуулж, ЗГ-аар хэлэлцүүлэн, УИХ-аар батлуулах бэлтгэл ажил хийгдэж байна.		
	Арга хэмжээ 1.6. Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулах	Барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн хувь	80%	90%	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдээс Геронтологийн төвийн барилгын ажил 2019 оноос хойш царцсан. Барилга угсралтын ажлын зураг төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт өртөг нэмэгдсэн. Шинжээчийн дүгнэлт гаргуулах хүсэлтийг 2023 онд ҮАГазарт хүргүүлж, дүгнэлтийг АТГ, СЯ-нд тус тус хүргүүлсэн. Иймд Нийслэлийн Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороонд баригдаж байгаа Сэргээн засах төвийн барилгыг		

					дуусгаж, Геронтологийн үндэсний төв болгон ашиглахаар төлөвлөсөн. Ажлын явц 95 хувьтай байгаа ба 2025 оны 3 дугаар улиралд багтаан ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байгаа ба улсын комисс ажиллуулах бэлтгэл ажил хийгдэж байна.		
Зорилт 2. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эрүүл мэндийн салбарын барилга, байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн жилийн болон дунд хугацааны төсвийн саналыг нэгтгүүлэх үйл ажиллагаа							
1	Арга хэмжээ 2.1. Эрүүл мэндийн салбарын Барилга байгууламжийн шилжих 26, шинэ 1 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжилтийг ханган гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ. /МУ-ын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын/ XXII.1.1-XXII.1.30/	Санхүүжилтийн хувь	33%	30%	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар нийт 327,2 тэрбум төсөвт өртөг бүхий 104,8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй нийт 30 барилга байгууламжийн төсөл, арга хэмжээнээс шилжих 29, шинээр хэрэгжүүлэх 1 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс 2025 оны эхний хагас жилийн байдлаар 17 төсөл, арга хэмжээний 24.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна.	2025-01-01 2025-06-13	100%
	Арга хэмжээ 1.2. Эрүүл мэндийн салбарын их засварын ажлын шилжих 2, шинэ 3 төсөл, арга хэмжээний батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжилтийг ханган гүйцэтгэлээр нь санхүүжүүлнэ. /МУ-ын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын/ XXII.2.1-XXII.2.5/	Санхүүжилтийн хувь	21%	30%	Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар нийт 37,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 19,3 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй их засварын ажлын шилжих 2, шинэ 3 төсөл, арга хэмжээ батлагдсан. Үүнээс эхний хагас жилийн байдлаар 2 төсөл, арга хэмжээний 2,4 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон.	2025-01-01 2025-06-13	100%

					3 шинэ төсөл арга хэмжээний нийт 7 багцаас 6 багцад гэрээ байгуулж, ажил эхэлсэн. УНТЭ 1.3 тэрбум төгрөгийн засварын ажлын зураг төсөв ирүүлээгүй тул ТХТХуулийн 13.1.1 дэх заалтын дагуу гэрээ байгуулагдаагүй.		
3	Улаанбаатар хотод 2-р шатны Эрүүл мэндийн төвийг барина.	Барилгын ажлын зураг төслийн гүйцэтгэлийн хувь	0	50	Тус ажлын хүрээнд “Хүүхдийн эмнэлгийн барилга /Баянгол дүүрэг/-ыг барихаар төлөвлөсөн Иймд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Хүүхдийн эмнэлгийн барилгын зураг төсөв боловсруулах ажил”-ын төсөв 410,0 сая төгрөг батлагдсан бөгөөд 2025.06.10-ны өдөр худалдан авах ажиллагааг зарласан. 2025.07.01-ний нээл хийхээр төлөвлөн ажиллаж байна.		0
Зорилт 5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх							
1	Арга хэмжээ 4.1 Удирдлагууд болон холбогдох байгууллагыг мэдээллээр хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх	Боловсруулсан мэдээллийн тайлан	-	-	Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу 140 эрүүл мэндийн байгууллагуудын хүсэлтийг үндэслэн баталсан бөгөөд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон эрх шилжүүлэх, зарлах, гэрээ бүртгэх, тайлагнах үйл ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны цахим	2025-01-01 2025-06-10	100%

					систем болох tender.gov.mn зохион байгуулан ажилласан.		
	Арга хэмжээ 4.2 Албан бичиг, өргөдөл гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэж, ажлын цагийг мөрдөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухайд нь биелүүлэх	Албан бичиг шийдвэрлэлтийн хувь	-	-	Албан хэрэг хөтлөлтийн цахим систээр эхний хагас жилийн байдлаар 269 албан бичиг ирснээс 252 албан бичиг шийдвэрлэсэн бөгөөд 19 албан бичиг шийдвэрлэгдэх шатандаа байна.	2025-01-01 2025-06-10	100%
	Арга хэмжээ 4.3 2025 оны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргах	ХАСХОМ-ийг хуулийн хугацаанд тайлагнасан байна.	0%		2025.02.15-ны өдрийн дотор Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгийг гаргасан.	2025-01-01 2025-06-10	100%
	Арга хэмжээ 3.3 Өөрийн хариуцсан албан тушаалын хүрээнд архив, албан хэрэг хөтлөлтийг стандартын дагуу зохион бүрдүүлж хүлээлгэн өгөх.	Архивд хүлээлгэх өгсөн баримтын тоо	0%		Хугацаа болоогүй	2026-01-01 2026-06-10	

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1	Худалдан авах ажиллагааны мэргэжилтэний албан үүргийг давхар гүйцэтгэж байна	-	-	-	Сангийн сайдын 2023 оны 250 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын дагуу 140 эрүүл мэндийн байгууллагуудын хүсэлтийг үндэслэн баталсан бөгөөд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон эрх шилжүүлэх, зарлах, гэрээ бүртгэх, тайлагнах үйл ажиллагааг Төрийн	2025.03.07 2025.06.10	100%

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	Арга хэмжээ 1.1. Мэргэжил дээшлүүлэх чиглэлээр сургалт, семинарт оролцох	Сургалт, семинарын тоо	4	2	"Төсвийн хөрөнгө оруулалтыг төлөвлөх" 2 удаагийн	2025-01-01 2025-06-10	100%
	Арга хэмжээ 1.2. Төрийн албаны тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж болон Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг судлах	Эрүүл мэндийн салбарын эдийн засаг, төлөвлөлттэй холбогдолтой асуудлыг бие даан судлах	3	Эрхэлсэн ажлынхаа хүрээнд холбогдох хууль, дүрэм, журам, шинэчлэгдэх бүрд судлан мэдлэгээ дээшлүүл	Төрийн албаны тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж болон Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хуулиудыг судалж	2025-01-01 2025-06-10	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөрөнгө оруулалтын хэлтсийн Барилга байгууламж, их засварын хөрөнгө оруулалтын бодлого, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

 /М.Гэрэлтуяа/

(Албан тушаал)

(Нэр, гарын үсэг)

(Огноо)